



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/290

Сүхбаатар сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 тоот тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 4.4, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энэхүү захирамжийн хавсралтад дурдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргасан 4 иргэнд 769м² газрын эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.


2.Дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож газар эзэмших эрх зүйн харилцаа үүсгэн, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3.Эзэмшилд олгогдсон газраа тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг дээрх нэр бүхий газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Газар эзэмшигчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/-д хариуцуулсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/363 тоот, 2014 оны 06 дугаар сарын 23-ны А/256, 2013 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/350 тоот, 2015 оны 09 дугаар сарын 09-ны А/375 тоот захирамжийн иргэн А.Сауле, С.Нолхоосүрэн, Ё.Батзул, Д.Гантөмөр нарт холбогдох заалт, гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 17 сарын 14-ны өдрийн
А/350 тоот захирамжийн хавсралт

№	Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага		Нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Газар эзэмших эрх сунгах хугацаа	Хүчингүй болсон гэрчилгээ, гэрээний дугаар /гайлбар/
	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр	Регистр, улсын бүртгэлийн дугаар						
1	Ботакара Азей Сауле	МНУ77052368	4308012276	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Д.Оюунболд 1-р гудамж 101 а тоот	237	худалдаа үйлчилгээ	15 жил	аймгийн Засаг даргын 2012-10-25-ны өдрийн А/363 тоот захирамжийн 1-р хавсралтын А.Сауле /МНУ77052368/-д холбогдох хэсэг, 427529 дугаартай гэрчилгээ, 00518 тоот гэрээ
2	Монгол Сэмжид Нолхоосурэн	ЧК60090323	4308003789	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Их суварга 1-р гудамж Г-8 тоот	42	авто гарааш	15 жил	аймгийн Засаг даргын 2014-06-23-ны өдрийн А/256 тоот захирамжийн 1-р хавсралтын С.Нолхоосурэн /ЧК60090323/-д холбогдох хэсэг, 503696 дугаартай гэрчилгээ, гэрээ
3	Зая Боржигон Бндонжамц Батзул	МНУ75091260	4308003594	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Их суварга 2-р гудамж 203 тоот	400	худалдаа үйлчилгээ	15 жил	аймгийн Засаг даргын 2013-10-24-ны өдрийн А/350 тоот захирамжийн 1-р хавсралтын Е.Батзул /МНУ75091260/-д холбогдох хэсэг, 459845 дугаартай гэрчилгээ, гэрээ
4	Шальдынхан Дүгэржав Гантөмөр	МЛ69020413	4308001926	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Их суварга 2-р гудамж 206 тоот	90	Гэр орон сууцны хашааны газар	15 жил	аймгийн Засаг даргын 2015-09-09-ны өдрийн А/375 тоот захирамжийн 1-р хавсралтын Д.Гантөмөр /МЛ69020413/-д холбогдох хэсэг, 575557 дугаартай гэрчилгээ, 01154 гэрээ
Нийт					769			